

ЗАГВАР 10: АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ЗАГВАР

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан АЗЗА" ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2024/05/НА-СА-ТӨА

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Дархан-Уул аймаг

2022 он

Тэргүүлэх аудитор: **Ш.Мөнхбаяр**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: [munkhbayarsh@audit.gov.mn](mailto:munkhbayarsh@audit.gov.mn)

Ахлах аудитор: **С.Батцэцэг**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: [battsetsegs@audit.gov.mn](mailto:battsetsegs@audit.gov.mn)

Аудитор: **Б.Алтанзул**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: [Altanzulby@audit.gov.mn](mailto:Altanzulby@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бүрхэлтийн гудамж-1, 14 дугаар баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг 45099,  
Утас: 7037-3085, Факс: (976) 7037-3088  
Цахим шуудан: darhanul-audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

᠒᠐2᠔.05.15 № 144

төгрөг \_\_\_\_\_ -ийг № \_\_\_\_\_ -г

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дархан АЗЗА" ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Дархан АЗЗА" ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон зүйл**

Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн 05 дугаар тогтоолоор арилжааны банкнаас зээл авахыг зөвшөөрсний дагуу 200.0 сая төгрөгийн зээл авсан байна.

**Аудитын гол асуудлууд**

Тайлант онд МУ-ын Засгийн газрын 220 дугаар тогтоолоор авто замын засвар арчлалтын компаниудыг нийлүүлэн "Авто замын засвар арчлалтын нэгтгэл" төрийн өмчит хувьцаат компани болгох шийдвэр гарсан.

**Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн жилийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 32 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 100 хувиар тайлагнасныг Зам тээврийн хөгжлийн яамнаас 86.85 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

᠒᠐᠒᠔.05.15

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР





## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрний дугаар	Балансын зүйл	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	-	-
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8,300,179.34	15,002,846.71
1.1.02	Дансны авлага	482,822,491.87	478,039,379.10
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	14,985,658.80	9,717,308.41
1.1.04	Бусад авлага	1,371,787.14	-
1.1.06	Бараа материал	418,008,665.03	395,522,955.50
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>925,488,782.18</b>	<b>898,282,489.72</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	-	-
1.2.01	Үндсэн хөрөнгө	1,026,115,160.20	924,487,902.76
1.2.02	Биет бус хөрөнгө	487,830,909.16	486,736,969.78
1.2.03	Биологийн хөрөнгө	2,075,000.00	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,516,021,069.36	1,411,224,872.54
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,441,509,851.54</b>	<b>2,309,507,362.26</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-
2.1	Өр төлбөр	-	-
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	-	-
2.1.1.01	Дансны өглөг	270,627,552.54	239,953,641.89
2.1.1.02	Цалингийн өглөг	-	-
2.1.1.03	Татварын өр	164,031,899.47	229,278,383.57
2.1.1.04	НДШ - ийн өглөг	132,420,614.00	166,177,836.32
2.1.1.05	Богино хугацаат зээл	2,045,458.41	1,387,705.67
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	17,439,000.00	17,439,000.00
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>586,564,524.42</b>	<b>654,236,567.45</b>
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.01	Урт хугацаат зээл	812,472,334.00	812,472,334.00
2.1.2.02	Нөөц /өр төлбөр/	-	-
<b>2.1.2.06</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>812,472,334.00</b>	<b>812,472,334.00</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,399,036,858.42</b>	<b>1,466,708,901.45</b>
2.3	Эздийн өмч	-	-
2.3.01	Өмч: - төрийн	582,966,824.33	582,966,824.33
2.3.02	- хувийн	-	-
2.3.03	- хувьцаат	-	-
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	169,381,142.45	169,381,142.45
2.3.07	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	704,928,568.65	704,928,568.65
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(414,803,542.31)	(614,478,074.62)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	65,882,960.75	(199,674,532.31)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(348,920,581.56)	(414,803,542.31)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>1,042,472,993.12</b>	<b>842,798,460.81</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,441,509,851.54</b>	<b>2,309,507,362.26</b>

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	1,712,121,306.36	1,318,348,895.51
02	Борлуулалтын өртөг	1,545,850,712.93	1,253,708,260.76
03	Нийт ашиг( алдагдал)	166,270,593.43	64,640,634.75
08	Бусад орлого	5,406,977.08	3,832,288.31
08.1	<b>Орлогын дүн</b>	<b>5,406,977.08</b>	<b>3,832,288.31</b>
10	Ерөнхий ба удирдлагын зардал	212,679,518.97	242,994,715.66
11	Санхүүгийн зардал	10,416,737.38	14,724,815.71
12.1	<b>Зардлын дүн</b>	<b>223,096,256.35</b>	<b>257,719,531.37</b>
17	Бусад ашиг ( алдагдал)	(14,464,274.91)	(10,427,924.00)
17.1	Олз, гарзын дүн	(14,464,274.91)	(10,427,924.00)
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	<b>(65,882,960.75)</b>	<b>(199,674,532.31)</b>
19	Орлогын татварын зардал	-	-
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(65,882,960.75)</b>	<b>(199,674,532.31)</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>(65,882,960.75)</b>	<b>(199,674,532.31)</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2021 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	582,966,824.33	-	134,917,715.01	704,928,568.65	(348,920,581.56)	1,073,892,526.43
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-
03	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-	-
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	(65,882,960.75)	(65,882,960.75)
05	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-
06	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-
07	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	34,463,427.44	-	-	34,463,427.44
09	2022 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	582,966,824.33	-	169,381,142.45	704,928,568.65	(414,803,542.31)	1,042,472,993.12
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	(199,674,532.31)	(199,674,532.31)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-
17	2023 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	582,966,824.33	-	169,381,142.45	704,928,568.65	(614,478,074.62)	842,798,460.81

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,731,583,152.61</b>	<b>1,482,436,129.91</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,654,635,426.17	1,413,808,676.11
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		5,942,452.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	116,000.00	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	76,831,726.44	62,685,001.80
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>1,569,897,070.71</b>	<b>1,499,107,750.85</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	346,606,712.71	379,389,511.92
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	35,859,909.12	75,132,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	470,429,714.00	549,538,702.82
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	8,778,872.49	8,466,492.99
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	466,265,807.01	90,178,856.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	9,752,697.59	12,458,823.45
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	157,628.00	37,384,811.62
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	114,750.00	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	231,930,979.79	346,558,552.05
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	161,686,081.90	(16,671,620.94)
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	<b>124,288.31</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	124,288.31
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	165,000,000.00	1,750,000.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>165,000,000.00</b>	<b>1,750,000.00</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	<b>200,000,000.00</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	200,000,000.00
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>2,500,000.00</b>	<b>175,000,000.00</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	175,000,000.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	2,500,000.00	-
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(2,500,000.00)</b>	<b>25,000,000.00</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(5,813,918.10)</b>	<b>6,702,667.37</b>
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,114,097.44	8,300,179.34
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,300,179.34	15,002,846.71

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	Зөрүү			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Үйлчилгээний орлого	746,356,384.50	727,000,000.00	756,654,432.00	29,654,432.00	104.1
Борлуулалтын орлого	963,225,367.30	618,000,000.00	560,039,168.00	(57,960,832.00)	90.6
Эрчмийн орлого	2,444,118.20		1,655,295.00	1,655,295.00	
Үйл ажиллагааны бус бусад орлого	5,502,431.60		3,832,288.00	3,832,288.00	
Үндсэн үйл ажиллагааны орлого	1,717,528,301.60	1,345,000,000.00	1,322,181,183.00	(22,818,817.00)	98.3
Бусад орлого	-	-	-	-	
<b>НИЙТ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,717,528,301.60</b>	<b>1,345,000,000.00</b>	<b>1,322,181,183.00</b>	<b>(22,818,817.00)</b>	<b>98.3</b>
Цалин хөлс	393,933,527.20	541,104,000.00	457,748,713.89	(83,355,286.11)	84.6
Материалын зардал	988,717,507.81	475,699,050.00	719,853,289.00	244,154,239.00	151.3
Ашиглалтын зардал	8,026,498.42	12,692,660.00	8,525,188.83	(4,167,471.17)	67.2
Засвар үйлчилгээний зардал	9,346,275.27	-	-	-	-
Ажиллагсадтай холбоотой зардал	46,857,638.29	104,954,200.00	48,135,540.18	(56,818,659.82)	45.9
Элэгдлийн зардал	85,151,663.79	112,927,000.00	112,513,822.03	(413,177.97)	99.6
Тээврийн зардал	122,834,852.14	15,500,000.00	63,591,381.82	48,091,381.82	410.3
Татвар даатгал төлбөр хураамжийн зардал	272,378.00	4,015,000.00	4,189,147.50	174,147.50	104.3
ТУЗ-ийн зардал	44,862,162.24	48,471,500.00	44,841,900.00	(3,629,600.00)	92.5
Бусад зардал	83,408,741.03	23,745,000.00	62,456,732.06	38,711,732.06	263.0
<b>НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,783,411,244.19</b>	<b>1,339,108,410.00</b>	<b>1,521,855,715.31</b>	<b>182,747,305.31</b>	<b>113.6</b>
ОЛЗ ГАРЗЫН ДҮН	-	-	-	-	
<b>НИЙТ АШИГ/АЛДАГДАЛ</b>	<b>(65,882,942.59)</b>	<b>5,891,590.00</b>	<b>(199,674,532.31)</b>	<b>(205,566,122.31)</b>	

**Гурав. Аудитын илрүүлэлт:** Аудитаар нийт 2,281.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup>, зөрчил илэрснээс аудитын явцад тайлант оны элэгдлийн зардлыг 1,017.8 мянган төгрөгөөр дутуу тооцоолсон байсныг залруулж, батлагдсан төсөлд холбоотой 1,263.7 төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 2 төлбөрийн акт тогтоосон.

## **5.1 Төлбөрийн акт**

**5.1.1** Тайлант онд 6 ажилтанд 637.3 мянган төгрөгийн ээлжийн амралтын цалинг илүү олгосон нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаалын хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.5-д "Ажилтанд олгож байгаа бүх төрлийн олговор (**богиносгосон цагаар ажиллах үеийн, сул зогсолтын үеийн олговор гэх мэт**), тэтгэмж (нярай хүүхэд үрчлэн авсан эцэг, эхэд олгох тэтгэмж гэх мэт), нөхөн төлбөр, хөнгөлөлт (унаа, хоолны үнийн хөнгөлөлт гэх мэт)-ийг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй" гэж заасантай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

**5.1.2** Компанийн 2023 оны батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд тусгагдаагүй 626.5 мянган төгрөгийн сургалтын төлбөрийг байгууллагын зардлаас төлсөн нь ТБОНӨТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.2 "*төрийн өмчит хуулийн этгээдийн өөрт олгогдсон эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах хэмжээ, хязгаарыг энэ хуульд нийцүүлэн тогтоох*", Дархан АЗЗА" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 07 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө"-тэй тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

## **5.2 Албан шаардлага**

Албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно.

## **5.3 Зөвлөмж**

Санхүүгийн холбогдолтой зөвлөмж өгөөгүй.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Тайлант оны элэгдлийн зардлыг 1,017.8 мянган төгрөгөөр дутуу тооцоолсон	1	1,017.8	-	-	1	1,017.8	1	1,017.8	-	-	-	-
Дүн	1	1,017.8	-	-	1	1,017.8	1	1,017.8	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд 6 ажилтанд 637,276.00 төгрөгийн ээлжийн амралтын цалинг илүү олгосон	1	637.3	1	637.3	-	-	-	-	-	-	-	-
Компанийн 2023 оны батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд тусгагдаагүй 626.5 мянган төгрөгийн сургалтын төлбөрийг байгууллагын зардлаас төлсөн	1	626.5	1	626.5	-	-	-	-	-	-	-	-
Дүн	2	1,263.8	2	1,263.8	-	-	-	-	-	-	-	-